

“7-р сарын 1. Хэвлэл мэдээллийн мониторинг”

Дөрөв. Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин

2008 оны 7 сарын 1-ний 23 цагт Монгол Улсын Ерөнхийлөгч 194 тоот зарлиг гаргаж, нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд 24 цагаас эхлэн дөрөв хоногийн хугацаатай онц байдал тогтоосон билээ. Зарлигийн 4-р зүйлд “Үндэсний олон нийтийн радио, телевизээс бусад телевизийн үйл ажиллагааг онц байдлыг цуцлах хүртэл зогсоох”-оор заасан юм. Ийнхүү зарлиг гаргахдаа 1995 оны 11 сарын 14-нд батлагдсан Онц байдлын тухай хуулийн 16-р зүйлийн 3 дахь хэсгийн 4-т “Олшруулах болон дуу авиаг чангаруулах техник хэрэгслийн ашиглалтыг хязгаарлах буюу хориглох, шаардлагатай бол түр хураан авах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоох, эсхүл онц байдлыг цуцлах хүртэл үйл ажиллагааг нь зогсоох” гэсэн заалтыг иш үндэс болгожээ.

Онц байдлын тухай хууль гарсан 1995 онд Монголд төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл давамгайлж байв. Үүнээс хойш Монголд хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах, төрийн мэдлийн ХМХ-ийг либеральчлах чиглэлээр чухал ахиц гарч, 1998 онд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, 2005 онд Олон нийтийн радио, телевизийн тухай хууль батлагдсан билээ.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийн 2-р зүйлд “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно”, 3-р зүйлийн 1-д “...Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй” мөн 3-р зүйлийн 2-т “Төрөөс ХМХ-ийн нийтлэх нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй” хэмээн тус тус заажээ.

Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 4-р зүйлийн 1-д: “Олон нийтийн радио, телевиз үйл ажиллагаандаа хараат бус байх, бодит мэдээлэл олж авах иргэний эрхийг хүндэтгэх, олон ургальч үзэл, ил тод байдлыг эрхэмлэх, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн, улс төрийн намын эрх ашгийг бус нийт үндэсний эрх ашгийг дээдлэх үндсэн зарчмыг баримтална” гэсэн байна. Мөн хуулийн 5 дугаар зүйлээр Олон нийтийн радио, телевизийн сурвалжлагч, редакцийн хараат бус байдлыг хангаж, нэг дэх хэсэгт: Олон нийтийн радио, телевизийн сурвалжлагч, редакци Үндсэн Хууль болон энэ хуулийн үзэл санаанд нийцсэн нэвтрүүлэг бэлтгэх, нийтийн хүртээл болгоход нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн, олон нийтийн радио, телевизийн удирдлага хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно” гэжээ.

Ерөнхийлөгч зарлигийн дагуу онц байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад МҮОНТВ-ээс бусад телевизийн үйл ажиллагааг зогсоож, МҮОНТВ-ийн мэдээллийн агуулгад цензур тогтоосон нь дээр дурдсан хуулийг зөрчиж, Онц байдлын тухай хуулийн хуучинсаг заалтыг хэтрүүлэн хэрэглэсэн гэж үзэж байна.